

ИРГЭДИЙН САНАЛД СУУРИЛСАН АВЛИГЫН ЭСРЭГ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН


Сүхбаатар аймаг

2014 он

Д/ д	Хийх ажлын агуулга	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хийж хэрэгжүүлсэн ажил
Нэг. Авлигын эсрэг соён гэгээрүүлэх , урьдчилан сэргийлэх арга хэмжээний чиглэлээр			
1	Авлигын эсрэг соён гэгээрүүлэх, авлигатай тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг боловсруулж хэрэгжүүлэх	<p>1.1.1. 2014 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг батлах.</p> <p>1.1.2. Төлөвлөгөө боловсруулахад төрийн албан хаагчид болон иргэдээс санал авч хэлэлцүүлэг зохион байгуулна.</p> <p>1.1.3. 2014 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийг Аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулах.</p> <p>1.1.4. Аймгийн Засаг Даргын захирамжаар батлуулан сумд, төрийн байгууллагад хүргүүлнэ.</p> <p>1.1.5. Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнг иргэд, олон нийтэд хэвлэл мэдээллийн хэрэгслээр ил тод, нээлттэй мэдээлж төлөвлөгөөний хэрэгжилтийг нэгтгэж, Аймгийн Засаг Даргын зөвлөлийн хуралд танилцуулна.</p> <p>1.1.6. Төлөвлөгөөг</p>	<p>Аймгийн Авлигын эсрэг үйл ажиллагааны 2014 оны төлөвлөгөөг боловсруулах ажлын хэсгийг Засаг даргын 2014 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн А/13 тоот захирамжаар 10 хүний бүрэлдэхүүнтэй томилсон ба ажлын хэсгийн ахлагчаар Засаг даргын тамгын газрын дарга Ц.Лхамсүрэнг томилж Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг хууль тогтоомжийн хүрээнд Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн шалгуур үзүүлэлттэй уялдуулан боловсруулж танилцуулахыг үүрэг болгосоны дагуу “Мерси-кор” Олон улсын байгууллагатай хамтран тус аймгийн Баруун-урт, Мөнххаан, Уулбаян, Сүхбаатар гэсэн 4 сумын төрийн албан хаагчид болон иргэдтэй уулзалт хэлэлцүүлэг зохион байгуулсан.Уулзалт хэлэлцүүлэгийн өмнө иргэдэд Авлигын тухай ойлголт өгөхийн тулд сургалт, сурталчилгаа зохион байгуулж харилцан ярилцаж 2013 онд Авлигын эсрэг хийж хэрэгжүүлсэн зарим ажлын талаар танилцуулав.</p> <p>Нийт 4 сумын иргэд, төрийн албан хаагчид оролцсон ба иргэдээс ирсэн саналыг нэгтгэн Аймгийн Авлигын эсрэг үйл ажиллагааны 2014 оны төлөвлөгөөнд тусгахаар амлалт өгч төлөвлөгөөнд 1 заалт болгон оруулсан. Аймгийн төлөвлөгөөг боловсруулах ажлын хэсэг нийт 20 хоногийн турш ажилласан 2014 оны төлөвлөгөөг амжилттай боловсруулж Засаг даргын зөвлөлд танилцуулан 2014 оны 01 дүгээр сарын 29-ний А/50 тоот захирамжаар аймгийн 2014 оны “Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө”-г баталж гаргав</p> <p>2014 оны “Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө”-г аймгийн “Шинэ Сүхбаатар” сонины 4 дүгээр сарын 02 тоот дугаарын 3, 4 дүгээр нүүр, “Sukhbaatar.mn” http://sukhbaatar.mn/index.php/2013-05-28-05-15-35/419-</p>

хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг төсөвлөн зарцуулна.

[plan.html](#) цахим хуудасанд байршуулсан ба агентлага, албад, сумдад хэвлэн хүргүүлсэн. Мөн 2014 оны “Авлигын эсрэг төлөвлөгөө”-г брошур болгон хэвлэж иргэдэд тараан танилцуулж хүн ихээр цугладаг худалдааны төвүүд, иргэний танхимаар тараан байршууллаа.



Аймгийн цахим хуудас /Sukhbaatar.mn/, орон нутгийн “Шинэ Сүхбаатар” сонин болон хэвлэмэл хуудас болгон хэвлүүлж иргэдэд тараасан билээ.




Орон нутгийн “BBS” телевизээр Тамгын газрын дарга Ц.Лхамсүрэн болон төлөвлөгөө боловсруулах ажлын хэсэг “Авлигын тухай ойлголт” болон “Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөө”-г таницуулах “Таны цаг” нэвтрүүлгийг 2014 оны 3 дугаар сарын 10, 16-ны өдрүүдэд 2 удаагийн давталттай нийт 4 удаа гаргасан.

Мөн “Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө”-ний хэрэгжилтийн явц, хэрэгжүүлэхэд гарч буй хүндрэл бэрхшээлийн талаар 9 дүгээр сарын 15-нд хэлэлцүүлэг зохион байгууллаа. Хэлэлцүүлэгт иргэний нийгмийн

			<p>байгууллагууд, иргэдийн төлөөлөл, төрийн байгууллагын дарга, албан тушаалтан нар оролцон өөрсдийн санал бодлоо солилцлоо.Хэлэлцүүлэгийн үер иргэний нийгмийн байгууллагаас Авлигатай тэмцэх газрын үнэлж, дүгнэх журмын дагуу авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний явц байдлыг үнэлж танилцууллаа.Авлигатай тэмцэх газраас баталсан үнэлэх шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлэхэд нийт 100 авахаас 50,5 оноо авч байна гэж дүгнэж өөрсдийн санал бодлоо солилцлоо.</p> <p>/Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө хэвлэсэн сонин болон хэвлэмэл хуудсыг хавсаргав/</p>
2	<p>Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчилах энэ талаар мэдээллийг байгууллага, иргэдэд чөлөөтэй авах нөхцлийг хангах</p>	<p>1.2.1. Аймгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны зардлын 20-иос доошгүй хувийг авлигын эсрэг соён гэгээрүүлэх, авлигатай тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээнд төлөвлөж зарцуулна.</p> <p>1.2.2. Авлигын эсрэг хууль тогтоомж, бусад хууль тогтоомжоор Дарьганга, Эрдэнэцагаан, Түмэнцогт, Онгон, Халзан, Түвшинширээ сумдад авлигын эсрэг, соён гэгээрүүлэх эрх зүйн сургалтыг, бусад сумд, байгууллагад санал хүсэлтийн дагуу эрх зүйн сургалтыг тус тус зохион байгуулна.</p> <p>1.2.3 Авлигын эсрэг хууль тогтоомж урьдчилан сэргийлэх чиглэлээр бэлтгэсэн кино, бичлэг, реклам, гарын авлага, зарыг орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр улиралд 1-ээс доошгүй удаа хүргэнэ.</p> <p>1.2.4. Авлигын эсрэг хууль</p>	<p>Хөдөө орон иргэд төрийн албан хаагчдад Авлигалын тухай ойлголт, ашиг сонирхлоос зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь, Авлигалын талаарх олон нийтийн ойлголт зэрэг сургалт, сурталчилгааг хийлээ. Сургалтанд 6 сумын 141 төрийн албан хаагчид, 101 иргэдэд хамрагдлаа.</p>  <p>Авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчилах, урьдчилан сэргийлэх зорилгоор Авлигатай тэмцэх газраас 7 төрлийн телевизийн шторк авч орон нутгийн BBS телевизээр улиралд 1 удаа 3 удаагийн давталттайгаар гарган сурталчилж байна.</p>

		<p>тогтоомж, 2014 онд хэрэгжүүлэх аймгийн авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг www.sukhbaatar.mn сайт дээр байршуулан сурталчилсан байна.</p>	<p>Авлигын эсрэг хууль тогтоомж, Аймгийн 2014 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг аймгийн цахим хуудас/ http://sukhbaatar.mn/index.php/2013-05-28-05-15-35.html/ -нд тухай бүр байршуулж ажиллаж байна.</p>
		<p>1.2.5. Авлигатай тэмцэх газраас бэлтгэн хүргүүлсэн сурталчилгааны материалыг сумд, байгууллага, иргэдэд хүргэх</p>	<p>Авлигатай тэмцэх газрын Хяналт үнэлгээ, дүн шинжилгээний хэлтсийн ажлын хэсэг 2014 оны 6 дугаар сарын 16-20, Урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх хэлтсийн ажлын хэсэг тус ирж ажилласан ба салбар ЭБАТ, болон төрийн албан хаагчид, иргэдэд сургалт, ярилцлага зохион байгуулсан. Тус сургалтанд давхардсан тоогоор 150 гаруй албан хаагчид, иргэд хамрагдан 4-6 төрлийн ном товхимол тараан өгсөн ба албан хаагчид, сумын ЗДТГ, ИТХ-ын ЭБАТ нарт тус бүр 50-60 ширхэг ном тараан өгсөн.</p>
		<p>1.2.6. Авлигын эсрэг олон улсын өдрийг угтан нийт агентлаг албадын дунд нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулах</p>	<p>Авлигын эсрэг олон улсын өдөр 12 дугаар сарын 9-нд болдог тул тухайн өдөр нээлттэй хаалганы өдөр зохион байгуулахаар төлөвлөөд байна.</p>
<p>Орон нутгаас батлагдан гарсан нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төслийг олон нийтэд танилцуулах сонирхогч бүлгүүдтэй харилцан санал солилцох</p>	<p>1.3.1. Боловсруулж байгаа бодлогын баримт бичиг болон нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээг тогтоосон шийдвэрийн төслийг www.sukhbaatar.mn вэб сайтанд тогтмол байршуулна.</p> <p>1.3.2. Дээрх бодлогын баримт бичиг болон шийдвэрийн төсөлд иргэд олон нийт сонирхогч бүлгийн санал шүүмжлэлийг хүлээн авах харилцан санал солилцох боломжийг бүрдүүлэх</p>	<p>Аймгийн Засаг даргын тамгын газарт байрлах иргэний танхимаар боловсруулж байгаа бодлогын баримт бичиг, нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээг тогтоосон</p>  <p>шийдвэрийн төслийг иргэд олон нийтийн дунд нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулж тэдний санал солилцох мөн мессеж үйлчилгээ ашиглан иргэдэд мэдээлэл хүргэж ажиллаж байна. Мөн Сүхбаатар аймгийн Иргэний танхимын Facebook /http://www.facebook.com/groups/155271297962779/ группээр дамжуулан Иргэний танхимд хэлэлцэх болон хэлэлцэж байгаа бүхий л мэдээллийг цаг алдахгүй мэдээлэж байна.</p>	

			<p>Тухайлбал 2014.04.18 Аймгийн ус цаг уур Орчны шинжилгээний албанаас Цаг агаарын урьдчилсан мэдээг хэрэглэгч, олон нийтэд хүртээмжтэй, үнэн бодитой мэдээлэх хэлэлцүүлгийг Аймгийн ИТХ-тай хамтран зохион байгууллаа. Уг хэлэлцүүлэгтэй ИНБ-ын төлөөллүүд болон иргэд оролцож тухайн мэдээллийг</p>  <p>хүлээн авлаа.</p> <p>2014.06.05-нд Иргэдийн хүний эрхийн талаарх мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх, хүний эрхийг түгээн дэлгэрүүлэх сурталчилах зорилготой Ерөнхий боловсролын сургуулийн 9-дүгээр ангийн сурагчдийн дунд Хүний эрхийн төлөө хичээлийн хэлэлцүүлэг,</p> <p>2014.06.10-нд Төрийн худалдан авах ажиллагааны ил тод өрсөлдөөнт байдлыг хэмжихэд ашиглаж буй индексийг боловсронгуй болгох чиглэлээр Мерси-Кор ОУБ-ын аймгийн төлөөлөгчийн газар, Худалдан авах ажиллагааны алба, МҮҮХХ-ны аймгийн салбар зөвлөл хамтран хэлэлцүүлгийг тус тус хийгээд байна.</p>
--	--	--	---

Хоёр.Төрийн хяналтын үйл ажиллагааны ил тод байдлыг хангах чиглэлээр


1	Төрийн хяналтын үйл ажиллагааны ил тод байдлыг хангах	2.1.1. Тухайн жилд явуулах хяналт шалгалтын ажлыг төлөвлөж оны эхэнд нийт иргэд, байгууллагад мэдээлсэн байна	www.inspection.gov.mn вэб сайтад хяналт шалтгалтын төлөвлөгөө хэсэгт
---	---	---	---

байршуулсан



1. Сүхбаатар аймгийн мэргэжлийн хяналтын www.su.inspection.gov.mn вэб сайтд шалгалтын дүнгийн танилцуулгыг байршуулдаг.

2.1.2. Мэргэжлийн хяналтын газраас хийгдсэн төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалтын дүнг тухайн орон нутгийн мэдээллийн хэрэгсэл, сум байгууллагын хурал дээр заавал мэдээлэх, аймгийн вэб сайтад байршуулах, шаардлагатай бол олон нийтэд ил тод мэдээлнэ.



Газрын даргын баталсан 44/89 тоот удирдамжийн дагуу хийгдсэн “Нийтээрээ эрсдэлээс сэргийлье” аяны шалгалтын дүнг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцэж, санал, дүгнэлтийг МХЕГ-т хүргүүлж ажилласан. Мөн хурлаас гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх үүднээс аймгийн Засаг дарга болон Баруун-Урт сумын Засаг дарга нарт 35, 36 тоот албан бичгийг хүргүүлж, хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлын шаардлага хангаагүй бүтээгдэхүүн борлуулсан аж ахуй нэгжүүдийн архи, тамхины тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож байхаар шийдвэрлүүлсэн.

Аймгийн МХГ-ын даргын 44/09 тоот удирдамжийн дагуу хийсэн шалгалтаар илэрсэн зөрчлүүдийг арилгуулах талаар холбогдох арга хэмжээг авахуулахаар Баруун-Урт сумын засаг дарга, аймгийн Боловсрол, соёлын газар, “Дөрвөлж” орон

нутгийн өмчит үйлдвэрийн газруудад хугацаатай албан тоот хүргүүлж, холбогдох арга хэмжээг авч, хууль тогтоомжийн хэрэгжилтэнд ахиц гарчээ.

Дарьганга, Наран, Онгон, Халзан, Сүхбаатар, Асгат, Эрдэнэцагаан сумдад хийсэн шалгалтын дүн, танилцуулгыг аймгийн засаг даргад хүргүүлж, сумдын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг хангуулж ажиллах талаар аймгийн ИТХ-д албан тоот хүргүүлэв. Мөн дээрх сумдын ундны усны чанар, аюулгүй байдал ямар түвшинд байгаа талаар нэгдсэн дүгнэлт гаргаж, аймгийн Засаг даргад хүргүүлсэн бөгөөд Баяндэлгэр, Уулбаян, Түвшинширээ, Мөнххаан, Түмэнцогт сумдад хийгдсэн шалгалтын дүнд үндэслэн аймгийн хэмжээнд тулгамдаж буй асуудлуудын талаар аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд хэлэлцүүлэхээр шийдвэрлэсэн.

Мөн шалгалт, судалгаа, мониторингийн хүрээнд хийсэн ажлын дүнд тулгуурлан “Худалдаа үйлчилгээнд тавих нийтлэг журам”-ыг батлуулахаар аймгийн ИТХ-д санал хүргүүлж, хурлын шийдвэр гэргуулж ажиллалаа.

“Сүхбаатар аймгийн мэргэжлийн хяналт” албан ёсны фэйсбүүк хуудсаар дамжуулан иргэдэд хяналт шалгалтын мэдээг танилцуулж байна.

Сүхбаатар Аймгийн Мэргэжлийн Хяналт
May 6 · 🌐

Малын эм ханган нийлүүлэх байгууллагын гэрээт борлуулагчдад хийсэн хяналт шалгалтын танилцуулга
Дэлгэрэнгүйг: <http://su.inspection.gov.mn/?p=722>

Малын эм ханган нийлүүлэх байгууллагын гэрээт борлуулагчдад хийсэн хяналт шалгалтын танилцуулга...

Мэргэжлийн хяналтын газрын 2014 оны бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээнд тусгагдсаны дагуу газрын даргын баталсан 44/17 тоот удирдамжаар Баруун-урт суманд үйл ажиллагаа явуулж байгаа малын эм ханган нийлүүлэх байгууллагын үйл ажиллагаанд

SU.INSPECTION.GOV.MN

Like · Comment · Share

Write a comment...

2. МХЕГ-ын www.inspection.gov.mn вэб сайтд шаардлагатай мэдээ мэдээллийг байршуулсан.



3. Орон нутгийн телевиз болох “BBS”, “SB” сувгуудаар хяналт шалгалтын мэдээлэл болон зөвлөмж, сэрэмжлүүлэг, нэвтрүүлгийг цацаж олон нийтийн хүртээл болголоо.

Төсвийн орлого, түүний зарцуулалт, гадаадын зээл, тусламж, түүний хувиарлалтыг олон нийтэд тухай бүр мэдээлнэ.

2.2.1. Тухайн жилийн төсөв, өмнөх оны төсвийн гүйцэтгэл, дараа жилийн төсвийн төслийг цахим хуудас болон байгууллагын мэдээллийн самбарт байршуулна.

2.2.2. Жилийн эцсийн санхүүгийн тайланг цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулна.

2013 оны төсвийн гүйцэтгэлийг ИТХ-д танилцуулан мэдээллийн самбар, аймгийн цахим хуудас/ <http://sukhbaatar.mn/index.php/tusuv.html/> -нд байршуулан олон нийтэд мэдээлсэн.

Мөн 2014 оны төсвийн хуваарийг сумд, агентлага, албад болон төсвийн захирагч нарт хүргүүлж ил тод байдлыг хангаж ажиллах талаар үүрэг өгч ажилласан.

2015 оны төсвийн төслийг ИТХ-аар танилцуулж 2014 оны 8 сарын 13,14-ны өдөр сангийн яаманд өргөн барьсан.

Санхүүгийн тайланг хагас бүтэн жилээр гарган цахим хуудас/ <http://sukhbaatar.mn/index.php/tusuv.html/>, хэлтсийн мэдээллийн самбарт байршуулсан ба 2013 оны санхүүгийн тайланг иргэний нийгмийн байгууллагын төлөөлөлд 2014 оны 03 сарын 22-ны өдөр танилцуулж ажилласан.

		<p>2.2.3. Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт бүрэн эхээр нь цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулсан байна.</p>	<p>2013 оны санхүүгийн тайлангийн материалыг 2014 оны 5 дугаар сарын 1-ний дотор хянуулж аудиторын санал, дүгнэлтийг хэлтсийн мэдээллийн самбар, аймгийн цахим хуудас/ http://sukhbaatar.mn/index.php/tusuv/427-audit.html/ -нд байршуулсан.</p>
		<p>2.2.4. Тухайн жилийн төсөвт орсон өөрчлөлтийн талаарх мэдээлэлийг тогтмол мэдээлнэ.</p>	<p>2014 оны төсвийн тодотголын талаарх мэдээллийг цахим хуудсанд тухай бүр байршуулан ажилласан.</p>
		<p>2.2.5. Төсвийн орлого бүрдүүлэлтийн нээлттэй байдал / татварын орлого, татварын бус орлогын талаарх мэдээлэл/</p>	<p>Орлого бүрдэлтийн талаарх мэдээллийг цахим/ http://sukhbaatar.mn/index.php/tusuv.html/ хуудсанд байршуулан ажилласан.</p>
		<p>2.2.6. Концессийн зүйлийн жагсаалт болон түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлт концессийн гэрээ байгуулсан тухай бүрт концесс эзэмшигч, түүний байгууллагын нууцад хамаарахаас бусад мэдээлэл, концессийн зүйл, гүйцэтгэх ажил, үзүүлэх үйлчилгээний талаарх мэдээллийг үндэсний хэмжээний өдөр тутмын хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр олон нийтэд түгээж цахим хуудас болон мэдээллийн самбартай ойлгомжтой байдлаар байршуулсан байна.</p>	<p>Концессийн гэрээгээр хийгдсэн ажил үйлчилгээ одоогоор байхгүй байна.</p>
		<p>2.2.7. Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, авсан даатгуулагчдын овог, нэрийг аймгийн вэб сайтад ил тод нээлттэй байршуулж мэдээлнэ.</p>	<p>Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, авсан тухай мэдээллийг аймгийн цахим хуудас/ http://sukhbaatar.mn/index.php/ndaatgal.html/ -нд хагас бүтэн жилээр нь тайланг гарган байршуулж ажиллаж байна. Хагас жилийн байдлаар:</p> <ol style="list-style-type: none"> 1. Тэтгэврийн сангаас 6368 тэтгэвэр авагч иргэнд 05 сарын байдлаар 68761,9 сая төгрөг олгов. 2. Шинээр 512 иргэнд тэтгэвэр тогтоож сард 857,3 сая төгрөг олгохоор, ажилласан жил нөхөн тооцуулж буй 300 тэтгэвэр авагчид тэтгэврийг

		<p>нэмэгдүүлэн өөрчилж сард 14,0 сая төгрөг олгохоор, 6259 тэтгэвэр авагчид ЗГ-н 15-р тогтоолоор 137,6 сая төгрөгийг сар бүр нэмэгдүүлэн олгохоор өөрчлөлтийг хийлээ.</p> <p>3. Тэтгэмжийн сангаас нийт 894 даатгуулагч иргэнд 376,7 сая төг тэтгэмж олгов. Үүнээс:</p> <ul style="list-style-type: none"> - Хөдөлмөрийн чадвараа түр алдсан 455 даатгуулагчид 27,8 сая төгрөг - Жирэмсэн болон амаржсаны тэтгэмж 267 даатгуулагчид 234,6 сая төгрөг - Оршуулагын тэтгэмж 107 даатгуулагчид 70,5 сая төгрөг, - Ажилгүйдлийн даатгалын сангаас 61 даатгуулагчид 43,1 сая төгрөг олгов. <p>4. ЭМД-д 41808 иргэн даатгуулсан ба ЭМД-н сангаас аймгийн нэгдсэн эмнэлэгт 396736,8 мянган төгрөгийг 7111 даатгуулагч иргэдийн эмчилгээний зардалд, 6350 даатгуулагч иргэний эмийн хөнгөлөлтөнд 37064,2 мянган төгрөг, хувийн хэвшлийн эмнэлгээр үйлчлүүлсэн 290 даатгуулагч иргэдийн эмчилгээний зардалд 42558,4 нийт 13871 даатгуулагч иргэний 476359,5 мянган төгрөгийн эмчилгээ үйлчилгээний зардалыг эмнэлэг эмийн сангуудад олгоод байна.</p> <p>Бүтэн жилийн тайлан гарах хугацаа болоогүй байгаа тул цахим хуудас болон самбарт байршуулаагүй байна.</p>	
		<p>2.2.8. Гадаадын зээл тусламжаар хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн талаарх мэдээллийг цахим хуудсанд байршуулна.</p>	<p>Гадаадын зээл тусламжаар хэрэгжиж буй төсөл хөтөлбөр одоогоор байхгүй байна.</p>
<p>3</p>	<p>Чиг үүргийн дагуу олгож буй зөвшөөрөл, бүртгэлийн үйл ажиллагааг ил тод, нээлттэй байлгах, олон нийтэд танилцах</p>	<p>2.3.1. Тухайн байгууллагаас олгож буй зөвшөөрлийн жагсаалт, түүнийг олгоход шаардлагатай баримт бичгийн жагсаалт, уг асуудлыг шийдвэрлэх журмын талаар вэб сайт болон тухайн байгууллагын мэдээллийн самбарт байршуулсан байна.</p> <p>2.3.2. Тусгай зөвшөөрөл</p>	<p>“Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн хууль”-ийн дагуу аймгийн Засаг дарга нь</p> <ol style="list-style-type: none"> 1. Эрүүл мэндийн байгууллага мэргэжлийн үйл ажиллагаа явуулах, 2. Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг байгуулах;

	<p>боломжоор хангана</p>	<p>эзэмшигчийн нэр, хаяг, эрхлэх үйл ажиллагааны чиглэл, зөвшөөрөл олгосон болон дуусгавар болох хугацааг цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байршуулна .</p> <p>2.3.3. Хуулиар хориглоогүй бүртгэлийн талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдлийг ханган цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулна.</p>	<p>3. Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх.</p> <p>4. Эмчилгээний гоо заслын үйлчилгээ гэсэн 4 төрлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгодог.</p> <p>Холбогдох хууль, тогтоол, журам, дүрэм, стандартад нийцүүлэн согтууруулах ундааны тусгай зөвшөөрөл олгох, сунгах, хяналт тавих журмыг аймгийн Засаг даргын захирамжаар батлан, хэрэгжүүлдэг бөгөөд хувийн хэвшлийн аж ахуй нэгж, иргэдийн зүгээс ирүүлсэн санал хүсэлтэд тулгуурлан өөрчлөх боломжтой.</p> <p>Энэхүү журмыг аймгийн Засаг даргын 2013 оын А/464 дүгээр захирамжаар батлан, 2013 оны 12 дугаар сарын 10-ны өдрөөс эхлэн хэрэгжүүлж, тусгай зөвшөөрөл олгох, сунгах үйл ажиллагаа эхлээд байна.</p> <p>Энэхүү зөвшөөрөлтэй холбоотой бүрдүүлэх материал, гарсан тусгай зөвшөөрлийн шийдвэрийн баримт бичгийг аймгийн цахим хуудас / http://sukhbaatar.mn/index.php/zahiramj.html/ -нд тухай бүр байршуулж ажиллаж байна. Тусгай зөвшөөрөл олгосон захирамж дээр тухайн байгууллагын нэр хаяг эзэмшигч гэх мэт мэдээллийг дэлгэрэнгүйгээр нь оруулан нийтэд мэдээлж байна.</p>
--	--------------------------	--	--

Гурав . Төрийн байгууллагын хүний нөөцийн ил тод байдлыг хангах, олон нийтийг түүнтэй танилцах боломжоор хангах чиглэлээр

1	<p>Төрийн байгууллагын хүний нөөцийн ил тод байдлыг хангах, олон нийтийг түүнтэй танилцах боломжоор хангах</p>	<p>3.1.1. Төрийн албаны сул орон тооны зарыг цахим хуудас болон мэдээллийн самбарт тухай бүр байршуулан нийтэд мэдээлнэ.</p> <p>3.1.2. Сонгон шалгаруулалт явуулах талаар орон нутгийн мэдээллийн хэрэгслээр тогтмол зарлана.</p> <p>3.1.3. Аймгийн ЗДТГ-ын хүний нөөцийн стратеги түүний</p>	<p>2014 онд Төрийн албаны сонгон шалгаруулалтыг нийт 3 удаа зарласан ба 53 сул ажлын байр зарлагдсанаас удирдах албан тушаалынх 5, мэргэжилтэн, байцаагч гээд гүйцэтгэх албан тушаалын 48 ажлын байранд 149 иргэн бүртгүүлэн 38 иргэн тэнцэж зарлагдсан ажлын байрандаа 9 иргэн томилогдон ажиллаж байна.</p> <p>Сонгон шалгаруулалтын зар болон Төрийн албанаас ирүүлсэн сонгон шалгаруулалтанд тэнцсэн иргэдийг баталсан тогтоолыг тухай бүрт нь Төрийн албаны цахим хуудас/ http://103.11.193.90/test/web/resource.php/, Аймгийн цахим хуудас/ http://sukhbaatar.mn/index.php/hunii-noots.html /, орон нутгийн BBS телевиз, самбарт тухай бүр байршуулан ажиллаж байна.</p> <p>Мөн аймгийн Засаг даргын тамгын газрын хүний нөөцийн стратеги төлөвлөөгөө боловсруулан батлуулж аймгийн цахим хуудас /</p>
---	--	---	---

		<p>хэрэгжилтийг хянаж, үнэлэх журмыг боловсруулж, орон нутгийн албан ёсны вэб сайтад байршуулна, албан байгуулагуудад жишиг болон ажиллана.</p>	<p>http://sukhbaatar.mn/index.php/hunii-noots.html/ -нд байршуулан бусад агентлаг, албад, сумдыг өөрсдийн байгууллагын төлөвлөгөөг боловсруулахыг үүрэг болгон ажиллаж байна. Мөн сонгон шалгаруулалтыг цахим хэлбэрээр 2 дахь жилдээ явуулж байгаа нь иргэдийн дундах элдэв цуу үг, сонгон шалгаруулалтын зохион байгуулж байгаа гишүүдийг өөрсдийн хүнээ тэнцүүлдэг гэсэн яриа бүр мөсөн үгүй болоод байна.</p>
		<p>3.1.4. Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний нээлттэй байдлыг ханган цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулж хэвшинэ.</p>	<p>Төрийн албан хаагчийн 2013 оны үр дүнгийн гэрээг журмын дагуу үнэлж, дүгнэн А, Б үнэлэгдсэн албан хаагчийн 59 албан хаагчийн зэрэг дэвийг нэмэх, 3 албан хаагчийн цалингийн шатлалыг нэмж урамшуулах мөн хангалтгүй үнэлэгдсэн албан хаагчийн зэрэг дэвийг буруулах арга хэмжээ авч ажиллаж байна.</p> <p>Албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэж дүгнэх хууль тогтоомж, дүрэм, журам, зэрэг дэв ахиулах, буруулах тухай захирамж гэх мэт мэдээллийг аймгийн цахим хуудас болон мэдээллийн самбарт тухай бүр байршуулж ажиллаж байна.</p> <p>Аймгийн хэмжээнд Сумдын засаг даргын тамгын газар болон төрийн нийт 35 байгууллагад ёс зүйн хороо байгууллагадан идэвхтэй үйл ажиллагаа явуулж байна</p>
		<p>3.1.5. Албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэх үйл ажиллагааг үнэн зөв, шударга болгох чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулж хэвшинэ.</p>	
<p align="center">Дөрөв . Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр, бараа ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах, түүнтэй танилцах боломжоор хангах чиглэлээр</p>			
1		<p>4.1.1. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтын журам, тендерийн урилга, тендер оролцогчидод тавих шалгуур үзүүлэлтийг ил тод нээлттэй байлгаж хэвлэл мэдээллийн хэрэгслээр хүргэсэн байна.</p>	<p>Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг 2013 оны 12 сарын 18-ны өдөр батлуулсан. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтын журам, тендерийн оролцогчидод тавих урилга, тендер оролцогчидод тавих шалгуур үзүүлэлтийг ил тод нээлттэй байлгаж үндэсний хэмжээний Зууны мэдээ, Өглөөний сонингуудад нийтэлсэн. Мөн Сангийн яамны www.e-procurement.mn, Сүхбаатар аймгийн Sukhbaaatar.mn, худалдан авах ажиллагааны албаны www.tender.sukhbaatar.mn сайтуудад болон байгууллагын мэдээллийн самбарт нийтэлсэн.</p>
		<p>4.1.2. Тендерийн урилгыг үндэсний хэмжээний олон нийтийн мэдээллийн хэрэгслээр нийтэд зарласан</p>	<p>Тендерийн урилгыг үндэсний хэмжээний Зууны мэдээ, Өглөөний сонингууд, Сангийн яамны www.e-procurement.mn, Сүхбаатар аймгийн Sukhbaaatar.mn, худалдан авах ажиллагааны албаны www.tender.sukhbaatar.mn сайтууд, байгууллагын мэдээллийн самбар болон орон нутгийн BBS телевизээр тухай</p>

	байна.	бүрт нь нийтэд мэдээллийг хүргэдэг
	4.1.3. Тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт болон гүйцэтгэчийг сонгон шалгаруулсан үндэслэлийн талаарх мэдээллийг цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулсан байна.	Тендерийн урилга бүрд тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлтийг гаргаж олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, байгууллагын мэдээллийн самбараар дамжуулан түгээдэг. Мөн тендерийг сонгон шалгаруулсан үндэслэл ажлын явцын талаарх мэдээллийг аймгийн албан ёсны веб www.sukhbaatar.mn , болон Худалдан авах ажиллагааны албаны www.e-procurement.mn сйатуудад болон байгууллагын мэдээллийн самбар зэрэгт байршуулахаас гадна жижиг хэмжээний 4-5 төрлийн 1500 орчим тараах материал гаргаж ард иргэд болон байгууллагуудад түгээсэн
	4.1.4. Тендер шалгаруулалтын тайлан мэдээ, аудитын дүгнэлт, хяналт шалгалтын дүнгийн талаар нээлттэй ил тод мэдээлнэ.	Худалдан авах ажиллагааны тайлан мэдээг Сангийн яамны www.e-procurement.mn , Сүхбаатар аймгийн Sukhbaatar.mn , худалдан авах ажиллагааны албаны www.tender.sukhbaatar.mn сайтууд, байгууллагын мэдээллийн самбар болон орон нутгийн BBS телевизээр тухай бүрт нь нийтэд мэдээллийг хүргэдэг.
	4.1.5. Худалдан авсан бараа ажил үйлчилгээний тайлангийн нээлттэй байдлыг хангана.	Өнөөдрийн байдлаар Худалдан авах ажиллагааны алба нь нийт төлөвлөгөөнд тусгагдсан 56 ажил байгаагаас 41 ажлыг зарлаж үнэлгээ хийсэн, 3 ажлыг яамнаас ирсэн зөвлөмжийн дагуу шууд гэрээ байгуулсан 6 ажлыг эрх шилжүүлсэн, зарлагдаагүй 6 ажил байна. Нийт төлөвлөгөөний биелэлт 98,2 хувьтай байна. Тендер шалгаруулалтын явцад тендертэй холбоотой гомдол зөрчил гараагүй. Энэ онд 30 үнэлгээний хороог Засаг даргын захирамжаар байгуулсан бөгөөд үнэлгээний хороо бүрд тухайн салбарын мэргэжлийн байгууллага, хувийн хэвшил, төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулсан.
	4.1.6. Тендер шалгаруулах явцад илэрсэн зөрчлийн талаар тухай бүр холбогдох бйгууллагад мэдээлж, тендерийн үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд тухайн салбарын мэргэжлийн байгууллага, хувийн хэвшил, төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулсан байна.	
	4.1.7. Худалдан авах ажиллагааны тодорхой хувийг цахим хэлбэрээр зохион байгуулна.	Худалдан авах ажиллагааны алба нь 1 тендерийг цахим хэлбэрээр зохион байгуулсан нь өнөөдрийн байдлаар төлөвлөгөөнд тусгагдсан нийт ажлын 20 хувьд хүрээд байна



Тав. Төрийн байгууллагын үйлчилгээний ил тод байдал, албан хаагчдын ажлын байрны ил тод байдлыг хангах чиглэлээр

1	5.1.1. Төрийн албан хаагч нэг бүрийн ажил үүргийн хуваарь, ажлын байрны тодорхойлолтыг баталж мөрдүүлсэн байна.	Албан хаагчдын ажил үүргийн хуваарь, ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн батлуулж цахим хуудсанд байршуулсан ба албан хаагчидаар мөрдүүлж ажиллаад байна.
---	---	--



	<p>Албан хаагч бүрийн үүргийн хувиарыг тодорхой болгох ажил</p>	<p>5.1.2. Хариуцсан ажил үүргийн чиглэлийн талаарх мэдээллийг нээлттэй болгоно.</p> <p>5.1.3. Авлигатай тэмцэх, урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх чиглэлээр /зорилго бүхий/ төрийн бус байгууллагаас ирүүлсэн бүтээлч, ажил хэрэгч төслүүдийг дэмжина. Боловсролын байгууллагууд, аймгийн Нэгдсэн эмнэлэг, ГХБХБГ, Хөдөлмөрийн хэлтэс, НХҮХ, Цагдаагийн хэлтэс, МХГ зэрэг байгууллагуудын үйл ажиллагаанд ТББ-аар судалгаа, шинжилгээ хийлгүүлж, үйл ажиллагааны үр дүнгийн талаар олон нийтэд нээлттэй, ил тод мэдээлэх ажлыг зохион байгуулна.</p>	<p>Иргэний нийгмийн байгууллагатай хамтран төрийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавих, тухайн байгууллагын албан хаагчдын харилцаа, ёс суртахуун авлига ашиг сонирголоос ангид, хүнд суртал, чирэгдэлгүй иргэдэд үйлчилж байгаа эсэх талаарх мэдээллийг байгууллагын удирдлагад танилцуулах зорилгоор 6 байгууллагад нийт 720 минутын бичлэг хийхээр төлөвлөн ажиллаж байна. Нэг байгууллага дээр нэг удаагын дүрс бичлэг нь 40 минут байх бөгөөд жилийн хугацаанд 3 удаа хийх ба 720: 6 =120минут – жилийн турш нэг байгууллага дээр хийх бичлэгийн хугацаа</p> <p>120 : 3 = 40минут – нэг байгууллага дээрхи нэг удаагын бичлэгийн хугацаа</p> <p>40 : 2 = 20минут – сард 20 минутаар 2 удаагын давталттайгаар бичлэг хийнэ.</p> <p>Тухайн байгууллагын удирдлага албан хаагчдад ямар арга хэмжээ авсан гарсан үр дүнгийн талаар эргэн бичлэг хийн танилцуулж байх юм.</p> <p>Одоогийн байдлаар нийт 9 удаагийн бичлэг хийгдсэн ба он гараад гарсан үр дүнгийн талаар эргэн 19 бичлэг хийхээр төлөвлөж байна.</p>
<p>Зургаа. Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр</p>			
<p>1</p>	<p>Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ёс</p>	<p>6.1.1. Авлигатай тэмцэх газраас өгсөн саналыг тусган байгууллагынхаа ёс зүйн дүрмийн төслийн боловсруулж батлуулна.</p> <p>6.1.2. Төрийн албан хаагч бүр ёс зүйн дүрмийг мөрдөн хэрэгжүүлж, түүнийг зөрчсөн албан тушаалтанд хуулийн дагуу холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.</p>	<p>2013 онд ёс зүйн хороог шинэчлэн баталж ёс зүйн дүрэмээ баталсан. Одоогоор тэрхүү дүрэмийг мөрдөн ажиллаж байна.</p>


	зүйн дүрмийг тогтоон мөрдүүлэх	6.1.3. Төрийн албан хаагчийн хүнд суртал, зөрчлийн талаарх мэдээлэл хүлээн авах тогтмол утас нээн ажиллуулж, бүртгэлийн дэвтэр хөтлөнө.	Төрийн албан хаагчдын хүнд суртал, зөрчлийн талаарх мэдээллийг тогтмол нээлттэй утас /70513511/-аар хүлээн авч эхлээд байгаа ба нээлттэй утсаар мэдээлэл өгөх тухай нээлттэй утсыг цахим хуудас, Тамгын газрын албан хаагчидын facebook, Аймгийн facebook/ https://www.facebook.com/pages/Sukhbaatar-aimag/436361369773802/ , бусад сурталчилгааны самбарт зэрэгт байршуулан олон нийтэд мэдээллийг хүргэж сурталчилж ажиллаж байна.Одоогийн байдлаар иргэдээс ирсэн өргөдөл, гомдол, санал хүсэлтээр албан тушаалтантай холбоотой гомдол ирээгүй байна.
		6.1.4. Тайлан мэдээг графикт хугацаанд АТГ-т хүргүүлнэ.	Хувийн ашиг сонирхол хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд албан хаагчдаас бүрэн авч тайланг Авлигатай тэмцэх газарт 2014 оны 03 дугаар сарын 15-ны дотор хүргүүлнэ. Хувийн ашиг сонирхолын урьдчилсан мэдүүлгийг хянуулж ажил албан тушаалд томилох явц муу байсан ба 2014 онд сайжруулан нийт Засаг даргаас шинээр томилогдсон болон ажил үүрэг нь өөрчлөгдөж буй 15 албан хаагчдын материалыг 100 хувь хянууллаа. Мөн 2012 оноос хойш шинээр томилогдсон болон ажил үүрэг нь өөрчлөгдсөн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг хянуулаагүй Аймгийн Засаг дарга болон Тамгын газрын дарга нараар томилогдсон 23 албан хаагчдыг үүрэгт ажлаас нь түр чөлөөлөн мэдүүлгийг хянуулан буцаан томиллоо.
2	Давхар эрхлэх боломжтой эсэх талаар төрийн албан хаагчдад мэдээлнэ.	6.2.1. Хууль болон засгийн газраас зөвшөөрсөн давхар ажил эрхэлж болох ажлын жагсаалтыг гаргаж албан хаагчдад танилцуулна.	Давхар ажил эрхлэж болох ажлын байрны жагсаалтыг Тамгын газрын зөвөлгөөн дээр албан хаагчдад танилцууллаа. Одоогоор давхар ажил эрхлэж байгаа албан хаагч байхгүй ба10 албан тушаалтан ажил хавсран гүйцэтгэж байгаа байна.
3	Байгууллагын удирдлагаас гаргаж буй шийдвэрийн илтгэл, нээлттэй байдлыг хангана.	6.3.1. Эрх бүхий албан тушаалтнаас гаргасан төрийн болон тухайн байгууллагын нууцад хамааруулсанаас бусад шийдвэртэй иргэд олон нийтэд танилцах боломжийг бүрдүүлнэ.	Аймгийн ИТХ-ын тогтоол http://sukhbaatar.mn/index.php/2013-05-27-08-52-46.html/ , Засаг даргын захирамж, Засаг даргын тамгын газрын тушаал нууцад хамаарахаас бусад шийдвэрүүдийг цахим хуудас/ http://sukhbaatar.mn/index.php/2013-05-28-05-15-35.html/ -нд, мэдээллийн самбарт тухай бүр байршуулан ажиллаж хэвшээд байна.
		6.3.2. Хууль тогтоомжоор зөвшөөрсөн төлбөр хураамжийн тарифыг баталсан шийдвэрийн хамт нүдэнд харагдахуйцаар илтгэл байршуулахыг хэвшүүлнэ.	Хууль тогтоомжоор зөвшөөрсөн төлбөр хураамжийн талаарх мэдээллийг мэдээллийн самбар, цахим хуудас/нд байршуулан иргэд олон нийтэд хүргэж үйлчилж байна.
Долоо . Иргэдийн өргөдөл, гомдол, хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэх			

шат дамжлагыг цөөрүүлэх хүрээнд


<p>Санал гомдол хүлээн авах шийдвэрлэх</p>	<p>7.1.1. Гомдол мэдээлэл хүлээн авах чиг үүргийг бүтцийн нэгж /ажилтан/-д хариуцуулж, тухайн ажилтаны овог, нэр, албан тушаал, ажиллах журам, харилцах утас, иргэдийн хүлээн авах цагийн хуваарийг цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулна.</p>	<p>Аймгийн ЗДТГ-ын Төрийн захиргаа, удирдлагын хэлтсийн мэргэжилтэн Б.Энхтуяа нь иргэдийн өргөдөл, гомдол, санал хүсэлтийг хүлээн авч эрх хэмжээний хүрээнд шийдвэрлэх буюу эрх бүхий албан тушаалтанд уламжлан, хуулийн хугацаанд шийдвэрлэн хариу өгч ажиллаж байна.</p>
	<p>7.1.2. Зөрчлийн талаарх мэдээлэл хүлээн авах нөхцлийг бүрдүүлэх /утас, хайрцаг, цахим гэх мэт хэлбэрээр/, зөрчлийн бүртгэлийн дэвтэр хөтөлнө.</p>	<p>Аймгийн албан ёсны вэбсайт хуудас болон Тамгын газрын мэдээллийн самбарт мэргэжилтний овог нэр, албан тушаал, ажил үүргийн хуваарь болон утасны дугаар, өрөөний тоотыг байршуулсан болно.</p>  <p>Нээлттэй утас /7051-3511/-ыг нээн ажиллуулж, иргэдийн санал, өргөдөл гомдол, зөрчлийн талаарх мэдээллийг хүлээн авч, ирүүлсэн мэдээллийг бүртгэлийн дэвтэрт хөтлөн ажиллаж байна. Мөн аймгийн ЗДТГ-ын үүдэнд Санал хүсэлтийн хайрцаг байршуулж, аймгийн ИТХ-ын дэргэдэх “Иргэний танхим”-д санал авч байна.</p> 
	<p>7.1.3. Гомдол мэдээлэлд дүн шинжилгээ хийж гомдол мэдээллийн мөрөөр тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.</p>	<p>2014 оны 3 дугаар улирлын байдлаар иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдол шийдвэрлэлт 92.2 хувьтай байна. Мөн өргөдөл, гомдлын тайланг улирал тутам гарган байгууллагын удирдлагуудад танилцуулан цахимд байршуулж байна.</p>

Найм. Албан хаагчдын шударга байдал ба түүнийг нэмэгдүүлэх чиглэлээр

1	<p>Албан хаагчдын шударга байдал ба түүнийг нэмэгдүүлэх чиглэлээр тодорхой арга хэмжээнүүдийг зохион байгуулна.</p>	<p>8.1.1. “Шударга ёс ба төрийн албан хаагчийн ёс зүй”, “Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга зам” гэсэн сэдвүүдээр төрийн албан хаагчдын дунд сургалт зохион байгуулах, зөвлөмж хүргүүлнэ.</p>	<p>Аймгийн иргэдийн хурлын нарийн бичгийн дарга / ЭБАТ/, Засаг даргын тамгын газрын хууль зүйн хэлтсийн сургалт сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн/ О.Саранчимэг/, Иргэний нийгмийн болон төрийн бус байгууллагын сургагч багш нартай хамтран төрийн албан хаагчид, салбар ЭБАТ-ууд болон иргэдэд 2 удаагийн сургалтыг бүрэн дунд сургуулийн ахлах бүлгийн сурагчид, нийгмийн ажилтан, нийгмийн тухай хичээлийн багш нарт 1 удаагийн Авлигын талаарх ойлголт, Ашиг сонирхлын зөрчил түүнээс урьдчилан сэргийлэх тухай сургалтын 2, 4 дүгээр сард зохион байгууллаа. Сургалтанд оролцсон сурагчид болоод багш нар өөрсдийн сургууль дээр сургалт сурталчилгааг хийсэн ба хийсэн сургалтын болоод зохион байгуулсан ажлын тайланг ирүүлж ажилласан. Мөн Авлигатай тэмцэх газрын Хяналт шинжилгээ дүн үнэлгээний хэлтэс, урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх хэлтсийн ажлын хэсэг төрийн албан хаагчид болон иргэдэд 6, 7 дугаар сард сургалт зохион байгуулсан.</p> 
		<p>8.1.2. Авлигад өртөх эрсдэлтэй ажил үйлчилгээ, албан тушаал, үйлчилгээний жагсаалтыг тодорхой судалгаа шинжилгээнд тулгуурлан гаргах тэдгээрт чиглэсэн соён гэгээрүүлэх урьдчилан сэргийлэх арга хэмжээг тогтмол хэрэгжүүлнэ.</p>	<p>Авлигад өртөх эрсдэлтэй ажил албан тушаал, үйлчилгээний жагсаалтыг 2 удаагийн судалгаа авч гарган тэдгээр ажил албан тушаалыг эрхэлж буй албан тушаалтнуудад сургалт сурталчилгааг 2 удаагийн сургалтыг хууль зүйн хэлтсийн сургалт сурталчилгаа хариуцсан мэргэжилтэй хамтран зохион байгууллаа. Мөн шинээр ажилд орсон болон авлигын эрсдэлтэй ажил албан тушаалтан гээд нийт албан хаагчдад “Авлигын эсрэг хууль”, “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхолыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчилөөс урьдчилан сэргийлэх” тухай хууль тогтоомжийг сурталчилах, хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэхэд нь нэмэр болох зорилгоор хуулийн зүйл заалтаас хэсэгчлэн компьютер болон нүдэнд харагдахуйц байдлаар тэдэнд байршуулж</p> 

			 <p>өгч байна.</p>
		<p>8.1.3. Эрсдэлтэй ажил, албан тушаал, үйлчилгээг эрхлэн гүйцэтгэж буй албан тушаалтан, ажилтаны үйл ажиллагааг хянах нөхцөл боломжийг бүрдүүлнэ.</p> <p>8.1.4. Байгууллагын дотоод аудит, хяналт шалгалт хариуцсан ажилтантай болно.</p>	<p>Нийт албан хаагчдаар “Авилгалаас ангид байх” баталгаа гарган гарын үсэг зуруулсан</p> <p>Монгол улсын Засгийн газрын тогтоол, Засаг даргын тамгын газрын цалингийн сан гэх мэт хэд хэдэн шалтгаанаас болоод оны эцэст дотоод аудит, хяналт шалгалт хариуцсан ажилтантай болхоор төлөвлөөд байгаа ба Хяналт шинжилгээ үнэлгээний тасгийн ажилтан давхар ажил хавсран гүйцэтгэхээр ажлын чиг үүрэгт нь тусгаж өгөхөөр болоод байна.</p>
<p>Ес. Иргэдээс ирүүлсэн саналын хүрээнд зохион байгуулах ажил</p>			
1	<p>Төрийн байгууллагын хүнд суртлыг багасгах, төрийн үйлчилгээг ил тод, хөнгөн</p>	<p>9.1.1. Аймгийн ЕБС-ийн ахлах ангийн сурагчидад Авлигын талаарх ойлголт” сэдвийг тодорхой хувиар хугацаатайгаар сургалт мэдээллийг зохион байгуулна.</p>	<p>“Авлигын тухай ойлголт, Нийгмийн хор аюул”, “Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай”, Жендерийн эрх тэгш байдлыг хангахад төр, иргэний үүрэг оролцоо”, Сайн засаглалын тухай ойлголт, зарчим” сэдэвт сургалтыг маш амжилттай зохион байгууллаа.</p>

шуурхай
болгох, улмаар
авлигаас
урьдчилан
сэргийлэх
зорилгоор мэдээллийг
хүртээмжтэй
байлгах, үйл
ажиллагаагаа
нээлттэй
болгох,
иргэдийн
оролцоог
хангаж
ажиллах
талаар
иргэдээс
ирүүлсэн
саналыг
хэрэгжүүлэн
ажиллана.



Сургалтыг Сүхбаатар аймгийн Засаг даргын тамгын газрын Хууль зүйн хэлтсийн Сургалт сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн О.Саранчимэг хийсэн ба Хүүхэд гэр бүл хөгжлийн хэлтэс, Халамж үйлчилгээний хэлтэс, Нийгмийн даатгалийн хэлтэс зэрэг байгууллагын ажилтан нар “Орон нутгийн хариуцлагатай засаглалын төлөөх идэвхтэй түшлэл ба иргэдийн оролцоо” аяны хүрээнд хийж гүйцэтгэсэн ажлуудаас товч мэдээлэл өглөө.





Энэхүү сургалтаар сурагчидад “ Авлига гэж юу вэ?”, “Түүнээс хэрхэн сэргийлэх, хэнд хандах ёстой вэ?”, Авлига өгчөх, авах нь зөв үү буруу гэдэг талаар ойлголт өгсөн ба нээлттэй харилцан ярилцсан сургалт боллоо.

Сургалтыг 2014 оны 4 дүгээр сарын 28-ны өдөр Аймгийн Засаг Даргын тамгын газрын хурлын зааланд төвийн 4-н бүрэн дунд сургуулийн ахлах бүлгийн төлөөлөл 40 гаруй сурагчид, Түүх нийгмийн 8 багш нар, 4 сургуулийн Нийгмийн ажилтан нарыг хамруулан зохион байгууллаа.

Сургалтанд хамрагдсан багш, ажилтан, сурагч нарт Авлигатай тэмцэх газраас хэвлэн гаргасан ном гарын авлага материалаар хангасан ба сургалтанд хамрагдсан багш, ажилтан, сурагч нар өөрсдийн сургууль дээр тухайн сэдвээр сургалтуудыг зохион байгуулах, сургалт зохион байгуулсан тайланг ирүүлэх үүрэг даалгавар авлаа.

/3-р бүрэн дунд сургуулийн авлигын эсрэг сургалт, сурталчилгаа зохион байгуулсан ажлын тайланг хавсаргав/

9.1.2. Төрийн албанд шинээр орж байгаа болон төрийн албанаас халагдсан чөлөөлөгдсөн албан хаагчдын мэдээллийг орон нутгийн албан ёсны вэб сайтаар мэдээлнэ.

Аймгийн Засаг даргын тамгын газарт шинээр орж буй албан тушаалтнуудын ажил үүрэг, албан тушаал, зураг холбоо барих утас гэх мэт мэдээллийг багтаасан мэдээллийг тухай бүр нь цахим хуудас / <http://sukhbaatar.mn/index.php/2013-05-28-09-57-20.html/> -нд байршуулж байна.

		<p>9.1.3. Төрийн албан хаагчдын ажил үүргийн хуваарь, албан хаагчдын зураг, овог нэр, ажлын байрны нэр холбогдох утасны дугаарыг албан хаагчдын өрөөний үүдэнд байршуулна.</p>	<p>Аймгийн Засаг даргын тамгын газар болоод тус байранд байрлаж байгаа байгууллага, төрийн байгууллагууд бүгд албан хаагчдын хаалганд тухайн албан тушаалтны албан тушаал, овог нэр, холбогдох утасны дугаар зурагийн хамт байршуулаад</p>  <p>байна.</p>
		<p>9.1.5. Ажлын байрны сул орон тоон дээр нөөцөд бүртгэгдсэн иргэдээс нөхөж аваагүй тохиолдолд мэдээллийн хэрэгслээр шалтгаан нөхцлийн талаар ил тод мэдээлж байна .</p>	<p>Төрийн албаны ажлын байрны сул орон тооны захиалгыг аван нөөцөөс нөхөх зарыг төрийн албаны цахим хуудас/ http://103.11.193.90/test/web/resadvert.php/ , аймгийн цахим хуудас/ http://sukhbaatar.mn/index.php/hunii-noots.html/ , орон нутгийн BBS телевиз, самбарт байршуулсан боловч ирж бүртгүүлсэн иргэн байхгүй байсан тул сонгон шалгаруулалтыг зарлан тэнцсэн иргэдээр сул орон тоог нөхөж ажиллалаа.</p>
		<p>9.1.6. Өргөдөл гомдлыг цахим хэлбэрээр авах боломжийг судалж бүрдүүлнэ.</p>	<p>Өргөдөл, гомдолыг одоогоор бичгээр, нээлттэй утас/70513511/, цахим хуудас / http://sukhbaatar.mn/index.php/2014-07-02-10-40-15.html/ -аар дамжуулан мэйлээр хүлээн авч эхлээд байна.</p>
		<p>9.1.7. Авлигын эсрэг соён гэгээрүүлэх үйл ажиллагаанд гудамж талбайд байрлах мэдээллийн самбаруудыг ашиглана.</p>	<p>Авлигын эсрэг соён гэгээрүүлэх үйл ажиллагааны дагуу гудамж талайд байрлах 2 самбарт авлигын талаар мэдээлэх аймгийн болон Авлигатай тэмцэх газрын утас, мэйл хаяг, цахим хуудас зэргийг агуулсан "Авлигын эсрэг хамтдаа" Авлига би өгөхгүй авахгүй" нэртэй 2 сурталчилгааны самбар</p>  <p>байршууллаа.</p>

9.1.8. Төрийн албан хаагч ажлын байран дээрээ ажлын цагаар байхгүй тохиолдолд шалтгаан нөхцлийнхөө талаар хаалган дээрээ мэдээлэл үлдээх нөхцлийг хангана.

Тамгын газрын албан хаагчдыг ажлын байран дээрээ байхгүй эзгүй байгаа тохиолдолд ямар ажлаас гарсан тухай илтгэх мэдээллийн хэсгийг ганцаараа суудаг албан хаагчдын үүдэнд олуулаа нэг өрөөнд суудаг албан хаагчдын ширээн дээр байршуулан тавьж хэвшээд



байна.



9.1.10. Шинээр гарч буй хууль тогтоомжийн талаарх мэдээллийг тухай бүрт нь орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр ард иргэдэд хүргэнэ.

Засаг даргын тамгын газраас төрийн үйлчилгээ болон төрийн хууль тогтоомжийг сурталчилах зорилгоор төрийн мэдээллийн цаг нэвтрүүлэг/<https://www.facebook.com/sukhbaatarprovince/posts/1465314760397719/> -ийг долоо хоног бүрийн баасан, бямба гарагт давталттайгаар иргэдэд хүргэж эхлээд дугаараа хүргээд байна. Мөн төрийн мэдээллийн цаг нэвтрүүлгийг youtube/https://www.youtube.com/results?search_query=turiin+medeelliin+tsag/-д байнга байршуулж ажиллаж байна. Энэхүү төрийн мэдээллийн цаг нэвтрүүлэгийг Засаг даргын тамгын газрын хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах мэргэжилтэн бэлтгэн хүргэж байна.

Мөн Иргэний танхимаар олон нийтэд сурталчилах, шинээр нэвтэрсэн мессеж үйлчилгээг ашиглан нийтэд мэдээллийг хүргэж ажиллаж байна.

9.1.11. ХЭҮК-ын санаачлагаар орон нутагт байгуулагдсан “Хүний эрхийн дэмжих бүлгэм” -тэй хамтран ажиллаж хариу нь өгөгдөөгүй санал хүсэлт, өргөдөл гомдлын нэгдсэн санг гаргаж шийдвэрлэлтэнд хяналт тавина.

Нийт ирсэн өргөдөл гомдолоос шийдэгдээгүй өргөдөл, гомдол байхгүй байна.

		<p>9.1.12. Орон нутгийн газар зохион байгуулалт, газар олголт, иргэдэд өмчлүүлэх болон эзэмшүүлэх боломжтой газрын талаар улирал тутам мэдээлж байх, газар эзэмшлийн талаарх мэдээллийг ил тод болгох</p>	<p>Аймгийн Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар нь орон нутгийн газар зохион байгуулалт, газар олголт, иргэдэд өмчлүүлэх болон эзэмшүүлэх боломжтой газрын талаарх мэдээллийг аймгийн цахим хуудас/ http://sukhbaatar.mn/index.php/2014-11-10-05-54-21.html/ -нд байршуулан ажиллаж байна.</p>
		<p>9.1.13. Төрийн байгууллага бүрт “Авлигын эсрэг үйл ажиллагааны ил тод байдлын мэдээлэл”-ийн самбар ажиллуулах</p>	<p>Авлигын эсрэг үйл ажиллагааны ил тод байдлын самбарыг Мэрси-кор олон улсын байгууллагатай хамтран төрийн байгуулагуудад хийж эхлээд байна.</p> 